# Иргэний нисэхэд ашигладаг нэр томьёоны тодорхойлолт, товчлолыг баримт бичигт тусгасан байдал

| | ИНД-ийн нэр томьёо | | Annex-ын нэр томьёо | | |
|---|---|---|---|---|---|
| | ИНД-ийн нэр томьёоны тайлбар | ИНД-1 Тодорхойлолт ба товчлол | AC01-0 Annex-ын нэр томьёоны болон товчлол | MNS 6409 : 2015 Иргэний нисэхийн Ерөнхий Нэр томьёо, тодорхойлолт | AIP GEN 2.2 НМҮ-ний хэвлэлүүдэд ашиглагдах товчлолууд |
| Тодорхойлолт | 390+159*=549 | 618 | 1008 | 781 | - |
| Товчлол | 194 | 79 | 1135 | - | 1079 |

ИНД-ийн нэр томьёоны тайлбар болон AC01-0 Annex-ын нэр томьёоны тайлбар болон товчлол нь өмнө ашиглаж байсан дараах 3 баримт бичгийн агууламжийг бүрэн хамардаг:

- ИНД-1 Тодорхойлолт ба товчлол;
- MNS 6409 : 2015 Иргэний нисэхийн Ерөнхий Нэр томьёо, тодорхойлолт;
- AIP GEN 2.2 НМҮ-ний хэвлэлүүдэд ашиглагдах товчлолууд.

Шинээр болон шинэчлэн боловсруулсан ИНД-ийн нэр томьёоны тайлбар болон AC01-0 Annex-ын нэр томьёоны тайлбар болон тайлбар нь хэрэглэхэд хялбар, хууль эрх зүйн хувьд үндэслэлтэй болсон төдийгүй ICAO Хавсралтууд, Doc 8400 болон NZCAR-н сүүлчийн өөрчлөлтүүдийг тусгасан баримт бичиг болсон.

2010 оны ИНД-1-д NZCAR Part 1-д байгаагүй, ИНД-д ашигладаггүй тодорхойлолтуудыг Doc 9713-аас нэмж оруулсан нь тодорхойлолтын тоог олон болгосон.

ИНД-ийн болон Annex-ын нэр томьёоны тайлбар нь батлагдахгүй удааширч байгаа нь ИНД-ийг хэрэгжүүлэх болон Annex, ИНД-ийн зөрүүг мэдээлэх зэрэг олон ажлыг саатуулж байна.

Ж-нь: Чикагогийн конвенцийн Annex 4-ийн зөрүүг мэдээлэх ажлын эхлэл болох нэр томьёоны тодорхойлолт нь нийт ажлын 16%-ийг эзэлдэг бөгөөд энэхүү ажлыг хийхийн тулд ИНД-ийн нэр томьёоны тайлбар болон Annex-ийн нэр томьёоны тайлбарыг батлан гаргах шаардлагатай байна.

Annex 4 Aeronautical charts

| Level of implementation | Definition | Standard | Recommendation | Note | Total |
|---|---|---|---|---|---|
| Not Applicable | 4 | | | 2 | 227 |
| More Exacting or Exceeds | - | 1 | - | - | 1 |
| No difference | 53 | | | - | 373 |
| Different in character or OMOC | 3 | 14 | 18 | - | 35 |
| Less protective | 58 | | | - | 93 |
| **Total** | **118** | **458** | **151** | **2** | **729** |

*Тайлбар*: Annex 4-т нийт 729 стандарт, зөвлөмжийн зөрүүг тодорхойлох ёстойгоос эхний 118 нь нэр томьёо байна.